МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

ТАЙЛАН

2025.05-Р САР

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ



БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДЭД ДОТООДЫН КОМПАНИУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД БОЛОН БУСАД ЧИГЛЭЛЭЭР НИЙСЛЭЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХААР БӨЛЛӨӨ

WWW.MNCA.COM

МБҮА

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

SINCE 2009

Зөв зүгт Манлайлна

АГУУЛГА

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

01
зАХИРГАА УДИРДЛАГА

02
АЖЛЫН АЛБА

03
ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУД

04
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

05
ДУЛААН ШИЙДЭЛ

06
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТ

www.mnca.mn



2025



ЗАХИРГАА-УДИРДЛАГА

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь 2009 онд үүсгэн байгуулагдаж, өөрийн эгнээндээ барилга, бүтээн байгуулалтын салбарт идэвхтэй үйл ажиллагаагаа явуулдаг томоохон хөрөнгө оруулагч, хөгжүүлэгч, үл хөдлөх хөрөнгийн реалтор, барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, архитектур, зураг төслийн чиглэлийн 160 гаруй гишүүн компаниудын бүтээн байгуулагчдыг сайн дурын үндсэн дээр нэгтгэж, гишүүддээ болон нийгэмдээ үйлчлэхээс гадна төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэдэг салбарын мэргэжлийн, манлайлагч, үндэсний бүтээн байгуулагчдын хамгийн том нэгдэл болох төрийн бус байгууллага юм. МБҮА ТББ нь Азийн ба Баруун Номхон Далайн Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон Улсын Нийгэмлэг (IFAWPCA)-ийн “УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН”, Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн холбоо (FIDIC)-ны “ТҮНШЛЭГЧ ГИШҮҮН”, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ)-ын УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮН” байгууллага юм.

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MNCA.MN

ХҮННҮ ХОТЫН ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН БҮС БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДУУЛАН БАРИЛГЫН МАТЕРИАЛ, ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ КОМПАНИУДТАЙ САНАЛ СОЛИЛЦЛОО



Нийслэл Улаанбаатар хотын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хүннү’ хотыг төрийн захиргаа, их дээд сургууль, тээвэр логистик, аялал жуулчлал, санхүүгийн төрөлжсөн дагууд хот болгон хөгжүүлэхтэй холбогдуулан 2025.05.27-ны өдөр барилгын материал, тоног төхөөрөмж, ханган нийлүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ, холбоодын төлөөлөлтэй уулзаж, санал солилцлоо.

Хурлын үеэр Хүннү хотын Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэгч, Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч М.Батбаяр “Улаанбаатар хотод 2025-2028 онд 24 мега төсөл хэрэгжүүлэх талаар Хүннү хотын Хөгжлийн корпораци ХХК-ийн захирал Г.Гүнболд Хүннү хотын тээвэр логистикийн төвийг байгуулах талаарх танилцуулгыг хийж шинэ хотын бүтээн байгуулалтад ААН-үүдтэй хамтран барилгын материалын ханган нийлүүлэлтийн үйл ажиллагааг цогцоор нь төлөвлөх шаардлагатай. Шинэ бүтээн байгуулалтыг төр дангаараа хийх боломжгүй учир төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шинэ хот тосгон, том төслүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Харин уулзалтын үеэр **МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх** “Засгийн газраас хэрэгжүүлэхээр төлөвлөөд буй томоохон мега төслүүдийг барилгын материалаар хангах шаардлага гарч байгаа. Эдгээр томоохон томоохон төсөл хөтөлбөрүүдийн барилгын материалд одоо байгаа эрэлт хэрэгцээнээс 2-3 дахин ихэснэ. Иймд барилгын материалынхаа 70 хувийг импортоор хангадаг манай улсын хувьд томоохон төслүүдээ явуулахад тээвэр логистикийн асуудал саатах эрсдэлтэй. Иймээс бид нийслэл болон Хүннү хоттойгоо хамтраад барилгын материалын логистикийн төвийг байгуулах асуудлаар Монголын Барилгын Үндэсний Ассоциаци, Барилгын Ханган нийлүүлэгчдийн Зөвлөл холбоод хамтран санал бодлоо солилцож, шийдэл гаргалгааны талаар танилцуулга хийлээ.

МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан: Эдийн засгийн чөлөөт бүс, логистикийн төвийн хөгжлийг ЗГ-ын бодлогоор дэмжиж, тусгай зөвшөөрөл, бодлогын уялдаа холбоо дээр хамтран ажиллах, хил хоорондын тээвэр, ложистикийн судалгаа, экспортын гарц, дотоодын оролцоог нэмэгдүүлэх талаар байр сууриа илэрхийлж төр, хувийн хэвшлийн түншлэлийг чухалчлав.

Уг арга хэмжээнд МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Дэд ерөнхийлөгч Д.Энхтөр, Гүйцэтгэх захирал Г.Батсүх тэргүүтэй удирдлагын багийнхан бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож Хүннү хотын бүтээн байгуулалтад барилгын компаниудын оролцоог хангах, чанартай барилгын материалыг нийлүүлэх нь Ложистикийн бүс байгуулахад нэн тэргүүний асуудал болохыг чухалчилж саналуудаа хэлж, ойлголцолд хүрлээ.

СЭЛБЭ ДЭД ТӨВИЙН ТЕНДЕРТ МОНГОЛ КОМПАНИ ОРОЛЦОХ БОЛОМЖГҮЙ АСУУДЛААР ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД ГОМДОЛ ГАРГАЛАА

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын бүтээн байгуулалтын тендерт ганц ч Монгол

компани оролцох боломжгүй нөхцөл тавиад хуулийн дагуу 2025.05.30-ны өдрийн дотор бүрдүүл гэх шаардлага тавьж байгаа нь техник өгөгдлийн буюу тендерийн худалдах авах ажиллагааны баримт бичигт сүүлийн таван жилийн борлуулалтын орлогоос аль нэг жилийн борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх гэсэн өндөр босго тавьсан байна.



Тухайлбал Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалтын төсөвт өртөг нь нийтдээ 840 тэрбум төгрөг, багц болгож хуваасан хэдий ч хоёрдугаар багц нь л гэхэд жилийн 136 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой байхыг шаарджээ. Өнөөдрийн нөхцөлд Монгол Улсад ийм хэмжээний орлоготой хувийн компани маш ховор. Нөгөө талаас энэ нь Монгол Улсын хуулийн этгээд, аж ахуй нэгж ажилтай, орлоготой байхын эсрэг зохицуулалт болж байна. Өөрөөр хэлбэл ийм хэмжээний төсөв, өртгийн боломжийг тендер зарласнаас 5 сарын дотор материалаа бүрдүүлж өгнө гэдэг бол Монгол Улсын Хуулийн этгээдийн хувьд асар хүндрэлтэй юм.

Уг нөхцөл шаардлагаас шалтгаалан гадаадын компаниудад давуу нөхцөл бүрдэж, дотоодын эдийн засаг, үндэсний компаниудын оролцоо хязгаарлагдаж, улсын эдийн засгийн хяналт, аюулгүй байдал алдагдах эрсдэл бий болоод байна.

Мөн Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд зааснаар төр эдийн засгийн зохицуулалт хийхдээ нийгмийн хөгжлийг хангах зорилготой байх ёстой. Гэтэл Монгол Улсын хуулийн этгээд орох боломжгүй шаардлага, бүрдүүлэхэд ч хүндрэлтэй давчуу цаг хугацаа тавигдах нь төсвийн зохицуулалт, үүнийгээ дагаад нийгмийн хөгжилд саад учруулсан Үндсэн хуулийн шаардлага зөрчсөн хуулийн зохицуулалт болж байна.

Төсвийн хэмнэлтийг зөвхөн орлого, зардлын хэмжээнд анхаарч, хэмнэлтийг хэрэгжүүлэх нь нийгмийн суурь хэрэгцээ, хүн амын амьдралын чанарыг хангахад сөрөг нөлөө үзүүлж байна. Тухайлбал, нийгмийн үйлчилгээний төсөвт хэмнэлт хийх нь тухайн чиглэлийн тусгай хөтөлбөр, төсөл, арга хэмжээг зогсоох, хойшлуулах, бүр цуцлах зэрэг үр дагаварт хүргэж, улмаар төрийн зүгээс хүлээсэн нийгмийн сайн сайхны төлөөх үүрэг, зорилгыг биелүүлэхэд саад учруулж байна.

Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь хэсгүүд нь батлагдсан төсөл, арга хэмжээг богино хугацаанд багтаахыг шаарддаг бөгөөд хугацаа хэтэрсэн тохиолдолд санхүүжилтийг хасах зохицуулалттай. Энэ нь тухайн төсөл арга хэмжээнд оролцох боломжийг хязгаарлаж, зарим тохиолдолд иргэдийн үндсэн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх нөхцөл үүсгэж байна.

Иймд төсвийн сахилга бат, хэмнэлтийн зорилго нь нийгмийн хөгжлийг хангах төрийн үндсэн чиг үүрэгтэй зөрчилдөхгүй, харин нийцтэй, тэнцвэртэй хэрэгжих шаардлагатай. Гэвч одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн эдгээр заалтууд нь Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан “эдийн засгийн зохицуулалт нь хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилготой байх” гэсэн үндсэн зарчмыг зөрчиж байна.

Мөн уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт зааснаар хэмнэлт нь хүлээн зөвшөөрөхүйц байх, үр ашигтай байх, бодитой байх, өөрчлөлт шинэчлэлтийг дэмжих гэх мэт зарчмыг баримтлахыг заасан. Нөгөө талаар маргаан бүхий Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтууд нь үндсэн зорилтдоо нийцээгүй, мөн Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан Эдийн засгийн аюулгүй байдал ба Төрийн хэмнэлтийн дээр дурдсан хуулийн

зохицуулалтуудын хүрээнд хэмнэлт хийх нь зөвхөн төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардал хэмнэхэд чиглэсэн байж болох ч зарим тохиолдолд төсвийн санхүүжилт зогсох, орхигдох нь эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай. Жишээ нь төрийн төсөл, арга хэмжээнүүдийн үргэлжлэл болон чанарт шууд нөлөөлж болзошгүй бөгөөд энэ нь нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлж, тогтвортой байдалд аюул учруулж болно.

Иймд Төрийн хэмнэлтийн тухай хууль, Үндсэн хуулийг зөрчсөн дээрх асуудлын хүрээнд иргэн Г.Батсүх нь Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцэд өргөдөл гаргаснаа хүлээлгэн өглөө.

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДЭД ДОТООДЫН КОМПАНИУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД БОЛОН БУСАД ЧИГЛЭЛЭЭР НИЙСЛЭЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХААР БОЛЛОО



Нийслэлээс хэрэгжүүлж буй төслүүдэд дотоодын барилгын компаниудад ерөнхий гүйцэтгэгчээр оролцох боломжийг бүрдүүлж, тухайн ажлыг хэсэгчлэн хуваан сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг шинэчлэх талаарх зөвлөмж гаргаснаа МБҮА ТББ нь Нийслэлийн удирдлагууд болоод холбогдох яаманд албан бичиг хүргүүлж улмаар шат шатны уулзалтуудыг хийсэн билээ.

Уг асуудлын хүрээнд 2025.05.16-ны өдөр МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан тэргүүтэй Удирдах зөвлөлийн гишүүд, Гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүтээн байгуулалтыг хийж буй компанийн захирлууд Нийслэлийн Засаг Даргын Эдийн Засгийн Хөгжил, Дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Сэлбэ дэд төвийн дарга У.Баатар нартай "Санамж бичиг" үзэглэлээ. Талууд:

Олон Улсад хүлээн зөвшөөрөгдсөн инженеринг, барилгын гэрээний жишиг нөхцөлийг орчуулах, нутагшуулах, хэрэглэхтэй холбоотойгоор мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх, хамтарсан санаачилга гаргах, шаардлагатай төсвийг тусгах чиглэлээр хамтран ажиллана;

Хөгжлийн төслүүдийн хүрээнд дотоодын компаниудын оролцоог хангах, давуу эрхийг үнэлгээнд тусгах, оролцох боломжоор хангах арга хэмжээг холбогдох хууль, журамд нийцүүлэн хэрэгжүүлнэ;

Барилга, дэд бүтэц, үл хөдлөх хөрөнгө, эрчим хүч, худалдан авах ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал боловсруулах, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллана;

Инженер, техникийн мэргэжлийг олон нийтэд сурталчлах, оюутан, суралцагчдыг дэмжих, нийслэлийн хөгжлийн төслүүдэд инновац, тэвшилтэт технологийг нэвтрүүлэх санал гаргах, хэрэгжилтэд нь хамтран оролцох чиглэлээр талууд харилцан дэмжиж ажиллах чиглэлээр “Санамж бичиг”-т тусгагдсан чиглэлүүдээр нийслэлийн хэрэгжүүлж буй томоохон төслүүдийн хүрээнд хамтран ажиллахаар боллоо.

Улмаар санамж бичигт зурсан ажлуудыг ажил хэрэг болгохоор “Ажлын хэсэг”-ийг газар дээр нь байгуулан эрчимжүүлэхээр тохирлоо.

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТӨСЛҮҮД ДЭЭР МОНГОЛЫН БАРИЛГЫН КОМПАНИУД ХЭРХЭН ХАМТРАН АЖИЛЛАХ ТАЛААР НИЙСЛЭЛИЙН УДИРДЛАГУУДТАЙ САНАЛ СОЛИЛЦЛОО



МБҮА ТББ нь 2025.04.30-ны өдөр төрийн яамд болон барилгын салбарын төрийн бус байгууллагууд, компаниудын 200 гаруй төлөөллийг оролцуулсан “CONSTRUCTION MARKET 2025” форумыг амжилттай зохион байгуулж, барилгын салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлыг хэлэлцэж салбарын мэргэжилтнүүд санал бодлоо илэрхийлсэн билээ.

Уг арга хэмжээний үеэр олон улсын геополитик, худалдааны дайн нь хөрш орны болон дотоодын эдийн засгийн нөхцөл байдалд муугаар нөлөөлж байгаа энэ үед дотоодын барилгын салбарын ААН, компаниудыг дэмжих бодлого нэн шаардлагатай байгаа болон 2025-2028 онд нийслэлд хэрэгжих Сэлбэ дэд төв, Туул хурдны зам зэрэг барилга бүтээн байгуулалтын төслүүдэд дотоодын барилгын компаниуд ерөнхий гүйцэтгэгчээр оролцох боломжийг бүрдүүлж, тухайн ажлыг хэсэгчлэн хуваан сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг шинэчлэх талаар зөвлөмж гаргаснаа Нийслэлийн удирдлагууд болоод холбогдох яаманд албан бичиг хүргүүлсэн юм.

Уг асуудлын хүрээнд 2025.05.12-ны өдөр МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Дэд ерөнхийлөгч Б.Нэмэхбаатар, Гүйцэтгэх захирал Г.Батсүх, Удирдах зөвлөлийн гишүүд, Монголын Барилгачдын Нэгдсэн Холбооны Ерөнхийлөгч Ч.Наранбаатар болоод бусад барилгын компанийн захирлууд Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Т.Даваадалай болоод Төслийн Нэгдсэн удирдлагын нэгжийн удирдлагуудтай санал солилцлоо.


Учир нь МБҮА ТББ нь барилгын Гэрээлэгчид, хөрөнгө оруулагчид, ханган нийлүүлэгчид, зураг төсөл зохиогчид гээд Монгол Улсын барилга үл хөдлөхийн салбарын 250 гаруй аж ахуй нэгж байгууллагуудын нэгдэл бөгөөд сүүлийн 30 жилийн хугацаанд барилга орон сууц, үл хөдлөхийн томоохон төслүүдийг амжилттай хийж гүйцэтгэж ирсэн төдийгүй Улаанбаатар хотоос зарлан хэрэгжүүлэх гэж буй барилга орон сууцны төслүүдийг дотоодын аж ахуйн нэгжүүдийн хүчээр гүйцэтгэх хүн хүч, технологи, төслийн удирдлагын бүрэн чадамжтай гэдгээ илэрхийлээ.

Харин Нийслэлийн удирдлагуудын зүгээс Нийслэлд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд болоод цаашид аж ахуйн нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, багц хөтөлбөрүүдийн талаар танилцууллаа. Мөн дараагийн багц төслүүдийг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн өөрчлөлт, төрийн зүгээс барьж буй бодлого, инженерийн мэргэжлийг сурталчлах, Фидик-ийн гэрээн дээр хамтран ажиллах зэргээр шат дараалсан уулзалтуудыг хийх, “Ажлын хэсэг” байгуулах замаар хамтран ажиллах боломжтой талаар санал солилцлоо.

ХҮННҮ ХОТЫН ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН БҮСИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО

Нийслэлийн Улаанбаатар хотын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.4-т “Хүннү’ хотыг Нийслэлийн хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэх хүрээнд төрийн захиргаа, их дээд сургууль, тээвэр логистик, аялал жуулчлал, санхүүгийн төрөлжсөн дагууд хот болгон хөгжүүлнэ гэж батлагдсантай холбогдуулан “ХҮННҮ ХОТЫН ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН БҮСИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ” хэлэлцүүлгийг 2025.05.01-









ны өдөр Хангарди хотхонд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, “Хөшгийн хөндийн чөлөөт бүс”-ийн Захирагч Б.Саранчимэг, Хүннү хотын Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэгч, Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч М.Батбаяр, Улаанбаатар хотын Ерөнхий архитектор Ч.Төгсдэлгэр, Монголын Ложистикийн холбооны Ерөнхийлөгч А.Мөнхболд нар болоод бусад албаныхан барилгын салбарынханд Хүннү хотын тээвэр логистик, Улаанбаатар 2040 хөгжлийн төлөвлөгөө, төр хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчны талаарх мэдээ мэдээллийг өглөө. Уг арга хэмжээнд МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Дэд ерөнхийлөгч Б.Нэмэхбаатар, Д.Энхтөр, Гүйцэтгэх захирал Г.Батсүх тэргүүтэй удирдлагын багийнхан бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож Хүннү хотын бүтээн байгуулалтад барилгын компаниудын оролцоог хангах, чанартай барилгын материалыг үнийн хөөрөгдөлгүй тасалдалгүй нийлүүлэхэд анхаарч ажиллах талаар саналаа хүргэлээ.

МБҮА ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2022-2025 ОНЫ БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНЫ СҮҮЛИЙН ХУРЛАА ХИЙЖ БҮХ ГИШҮҮДИЙН ЧУУЛГАНЫ ТОВЫГ ЗАРЛАЛАА





МБҮА ТББ нь Дүрмийн дагуу Удирдах зөвлөлийн 2022-2025 оны бүрэн эрхийн хугацааны сүүлийн хурал 2025.05.09-ны өдөр болж өнгөрсөн гурван жилд хийсэн ажил 15 жилийн ололт амжилтаа МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан дүгнэж хамтран ажилласан Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчид, Удирдах зөвлөлийн гишүүд, нийт гишүүддээ талархал илэрхийлэн баяр хүргээд Үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа. Хурлын үеэр уламжлалт ёсоор МБҮА ТББ-д элссэн шинэ гишүүн байгууллагууд болоод Ховд аймгийн салбар зөвлөлийн тэргүүн Б.Туулайтулга, Дархан-Уул аймгийн салбар зөвлөлийн тэргүүн С.Дэлгэрбаяр нарт Гэрчилгээг гардуулж туг гардуулж өглөө. Мөн МБҮА ТББ-ын дараагийн чухал асуудал болох “Арбитр болон

маргаан шийдвэрлэх зөвлөл”-ийн цаг үеийн мэдээлэл болоод Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ын 2025-2030 оны стратеги төлөвлөгөө



боловсруулах Ажлын хэсэг байгуулах тухай, Бүх гишүүдийн чуулган зохион байгуулах товыг тогтоох, хэлэлцэх асуудлыг хэлэлцүүллээ. Тус хурлаар Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ын 2025-2030 оны стратеги төлөвлөгөө боловсруулах ажлыг шинээр байгуулагдах Удирдах зөвлөлийн хуралд үлдээн бусад асуудлыг шийдвэрлэлээ. Түүний дараа санхүү болоод Хяналтын зөвлөлийн тайланг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт хийж улмаар МБҮА ТББ-ын 2025 оны Бүх гишүүдийн чуулганаар хэлэлцүүлэх “Монголын Барилгын Үндэсний Ассоциаци” ТББ-ын шинэчилсэн дүрмийн төслийг танилцуулж гишүүдийн саналыг авч чуулганы өмнө буюу 2025.06.20-ны өдрийн хурлаар батлуулахаар тогтлоо.

2025



САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MNCA.MN

ТАТВАРЫН БАГЦ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛТИЙН ТАЛААР БАРИЛГЫН САЛБАРЫНХАН САНАЛ СОЛИЛЦЛОО



УИХ-аас татварын багц хуулийн шинэчлэлийг удахгүй хэлэлцэн батлах гэж буйтай холбогдуулан МБҮА ТББ-ын Дэд ерөнхийлөгч Д.Энхтөр, Гүйцэтгэх захирал Г.Батсүх, МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Ш.Үнэнбат, Монголын Зөвлөх Инженерүүдийн Холбооны Ерөнхийлөгч Л.Шагдаррагчаа, Барилгын Материал Үйлдвэрлэгчдийн Холбооны Гүйцэтгэх захирал Б.Цэрмаа, МБҮА ТББ-ын гишүүн Цаст Констракшн ХХК-ийн төлөөлөл нартай “Татварын хөгжил дэвшил холбоо” ТББ-ын тэргүүн Б.Ганболд тэргүүтэй төлөөллүүд 2025.05.06-ны өдөр татварын багц хуулийн шинэчлэл талаар санал бодлоо солилцлоо.

Өнөөдөр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ууд орлогын албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвар, Нийгмийн даатгалын шимтгэл гээд татварууд төлөхөөс гадна Ажил гүйцэтгэх гэрээнээс нийгмийн даатгал авдаг нь компаниудад татвараа дийлэхгүй нөхцөл үүсэж байгаа, татварын өртэй учраас тендерт орж чадахгүй, улмаар данс хааж, хориг тавих нь тухайн компани үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй болж өр ужиграх, ажил үйлчилгээгээ бартераар явуулах гээд хүндрэл бэрхшээл гарч байгааг дурдлаа.

Дээрх нөхцөл байдлаас үүдэж барилгын салбарынхан Улаанбаатар хотын Мега төслүүдэд оролцох боломжгүй байгааг онцолсон юм.

Түүнчлэн татвар төлдөг аж ахуйн нэгж цөөн учраас далд эдийн засгийг нэмэгдүүлж, энэ нь орлогоо мэдүүлж татвараа төлдөг нь хохироод төлдөггүй хожих нөхцөл бүрдэж байна, татвар төлөгчдийн татварын боловсрол сул байгаа талаар ч анхааралдаа авах хэрэгтэй байгаа талаар саналаа солилцлоо.

Нөгөөтэйгүүр Татварын багц хуулиудыг шинэчлэхдээ үндэслэлтэй тооцоо судалгаа, үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай гэдгийг онцолж улмаар дараах асуудлуудад санал нэгдэж холбогдох газруудад саналаа хүргүүлэхээр боллоо.

-Татварын хууль нь татвар төлөгчид таатай орчин бүрдүүлэх, өрсөлдөх чадвартай байлгах ёстой учраас татварын хуулиудыг багцаар нь шинэчилж, зарчмын өөрчлөлт хийх,

-Татварын алба, татвар төлөгчийн үйл ажиллагааны тэнцвэрийг хангадаг байх, татвар төлөгдөхүйц байх зарчмыг хуульд тусгаж, татвар төлөлтийг үйл ажиллагаа идэвхждэг циклтэй уялдуулах, татвар төлөгч өөрөө татвараа төлөх боломжтой болгож, татвар төлөгчөө дэмждэг болох өөрчлөлтүүдийг хийх,

-Татварын хуулийн шинэчилсэн төслийг хийхдээ одоогийн хуулийн заалт бүрээр үнэлгээ хийх, Ажил олгогч, Ажилтан 2-ын нийгмийн даатгалын шимтгэлийн хувийг төдөн хувиар бууруулахад гарах өгөөж нь тэдэн хувь байна гэх зэрэг нотолгоотой тооцоо судалгаанд үндэслэх,

-Татварын хуулийн шинэчилсэн төслийг хийхдээ одоогийн хуулийн заалт бүрээр үнэлгээ хийх, Ажил олгогч, Ажилтан 2-ын нийгмийн даатгалын шимтгэлийн хувийг төдөн хувиар бууруулахад гарах өгөөж нь тэдэн хувь байна гэх зэрэг нотолгоотой тооцоо судалгаанд үндэслэх,

Татвар мөнгөн суурьтай байх уу аккуарел суурьтай байх уу гэдэг зарчмыг ч шинэчилсэн төсөлд тодорхой болгох гэдэг дээр санал нэгдлээ.

МБҮА ТББ-ын 2025 оны 4 дүгээр сарын төлөвлөгөөнд тус хэлтсийн шууд хариуцах 12 ажил, бусад нэгж, ажилтнуудтай хамтран гүйцэтгэх, оролцож ажиллах 4 ажил тусгаснаас гадна төлөвлөгөөнд ороогүй боловч шуурхай хурлуудаас өгсөн үүргүүдийг гүйцэтгэлээ. Үүнд:

Хамтран оролцсон, зохион байгуулсан ажлууд - Захиргаа, удирдлагын чиглэлээр:

МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн 2025 оны ээлжит II хуралдааны төлөвлөгөөний дагуу бэлтгэлийг Ажлын албанаас хангаж 2025.05.09-ний өдөр зохион байгууллаа. Хурлын хөтөлбөрийг урьдчилан батлуулж дараах асуудлуудыг хэлэлцүүллээ. Үүнд:

- МБҮА ТББ-ын 2022-2024 оны үйл ажиллагааны үр дүнгийн тайлан,
- МБҮА ТББ-ын 2025 оны үйл ажиллагааны үр дүнгийн тайлан,
- МБҮА ТББ-ын 2022-2024 оны санхүүгийн тайлан,
- МБҮА ТББ-ын Хяналтын зөвлөлийн 2022-2025 оны тайлан, дүгнэлт,
- МБҮА ТББ-ын 2025 оны бүх гишүүдийн чуулганаар хэлэлцүүлэх “Монголын Барилгын Үндэсний Ассоциаци” ТББ-ын шинэчилсэн дүрмийн төслийг танилцуулж, хэлэлцүүлэх,
- “Барилгын салбарын Хөрөнгө оруулагчдын чуулган-2025” олон улсын чуулганыг зохион байгуулах, холбогдох төсвийг батлуулах тухай,
- “Барилгын материалын тээвэр логистикийн төв” байгуулах төслийн тухай,
- МБҮА ТББ-аас байгуулсан “Арбитр болон маргаан шийдвэрлэх зөвлөл”-ийн мэдээлэл,
- МБҮА ТББ-ын 2025-2030 оны стратеги төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсэг байгуулах тухай,
- МБҮА ТББ-ын бүх гишүүдийн чуулган зохион байгуулах товыг тогтоох, хэлэлцэх асуудлыг батлах асуудлуудыг бэлтгэж хэлэлцүүллээ.
- МБҮА ТББ-ын 3 жилийн үйл ажиллагааны тайланг бэлэн болгож танилцуулахад бэлэн болсон.

Барилгын салбарын төрийн бус байгууллагуудыг гишүүнээр элсүүлэх чиглэлээр Гишүүнчлэл, хамтын ажиллагааны хэлтэстэй хамтран 70 гишүүн байгууллагатай Цахилгаан холбоо ТББ-ыг элсүүлэх ажил үргэжлэн явагдаж байна.

2.1 Салбарын бодлого, төлөвлөлт, судалгааны чиглэлээр

Барилгын ерөнхий хууль, Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төслүүдийн Ажлын хэсгийн хуралд тогтмол оролцож, хуулийн төсөлд саналаа хүргүүлж ажиллалаа. Барилгын ерөнхий хуулийн төсөл дээр зөвлөх үйлчилгээ үзүүлж буй Сайнхишиг ХХК-тай уулзаж хуулийн төслийн үзэл баримтлалд өгөх саналаа өгч ажилласан.

Хот байгуулалтын тухай хуулийн үзэл баримтлалын танилцуулгыг ХББОСЯ-тай хамтран хийж байна. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн төсөлд гишүүдээс санал авах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Үр дүн: МБҮА ТББ нь гишүүдийнхээ дуу хоолой болж хууль, төрийн бодлого, шийдвэрт санал бодлыг нь хүргэх чиг үүргээ хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулаа.

Барилгын ажил эхлэх зөвшөөрөл авах, архитектур төлөвлөлтийн даалгавар, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор НЗДТГ, ХББОСЯ-тай хамтарсан уулзалт зохион

байгуулав. Нийслэлийн засаг даргын 1-р орлогч Даваадалай, Төслийн удирдлагын нэгжийн удирдлагуудтай уулзалт хийж мэдээлэл солилцож, төрийн бус байгууллагуудын зүгээс саналаа илэрхийлж, хамтран ажиллах санамж бичиг байгуулахаар болсон. Нийслэлээс хэрэгжүүлэх мега төслүүд дээр НЗДТГ-тай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Энэ хүрээнд 2 тал тохиролцсон 4 чиглэлийг ажил хэрэг болгох 4 ажлын хэсэг байгуулан ажиллахаар боллоо.


Түүнчлэн Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын тендер шалгаруулалтуудад өөрчлөлт оруулж, үндэсний компаниудын оролцоог нэмэгдүүлэх талаар шаардлага, мэдэгдлийн төсөл боловсруулж барилгын салбарын 14 мэргэжлийн ТББ-уудыг нэгтгэн гарын үсэг зуруулан Төрийн тэргүүн, Их хурлын дарга, Ерөнхий Сайд, Нийслэлийн Засаг дарга нарт илгээснээс гадна уг асуудлаар Нийслэлийн ЗДТГ, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Сэлбэ 20 минутын хотын удирдлагад албан бичиг илгээв.

Төслийн санхүүжилт, төлбөр тооцоог боловсронгуй болгоход банк, даатгал, санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах, векселийн төлбөр тооцоог хэрэгжих боломжийг судалж, Хөрөнгийн бирж, үнэт цаасны компаниудтай уулзалт зохион байгуулахаар ярилцаж байна.

Үр дүн: МБҮА ТББ нь салбарын нийтлэг эрх ашиг, барилгын салбарын эдийн дархлааг хамгаалах дуу хоолой болж, гишүүдийн үйл ажиллагааг дэмжиж, тулгамдаж байгаа асуудлыг шийдэхэд хувь нэмэр оруулсан чухал ажил боллоо.

Салбарын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой 6 үзүүлэлт, барилгын материал үйлдвэрлэлтэй холбоотой 3 үзүүлэлтийг 2024 оны жинхэнэ гүйцэтгэлээр боломжит задаргаагаар татан авч мэдээллийг баяжууллаа. Орон сууцны бодлогоороо дэлхийн шилдэгт тооцогддог 6 улсын бодлогын баримт бичгүүдийг судалж, холбогдох тоон мэдээллийг цуглуулан авч мэдээллээ шинэчлэв.

Хүн амын орон сууцжуулалтын бодлого, орон сууцны нөхцөл сэдвээр судалгаа бэлтгэн цахим товхимол хэлбэрээр нийтэд түгээлээ. Орон сууцны бодлогоороо дэлхийн шилдэгт тооцогддог 6 улсын туршлагыг багтаасан “Хүн амыг орон сууцжуулах бодлого: Монгол Улс ба бусад улсын туршлага” сэдэвт судалгааг barilga.mn сэтгүүлд өгч, “Их барилга тооны хэлээр” контенийг олон нийтэд хүргэсэн болно



Барилгын салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудыг эрэмбэлэх ажлын хүрээнд судалгааны байгууллагуудад санал тавьж сонгон шалгаруулах зар бэлтгэлээ. Мөн энэ хүрээнд судалгааны SICA ХХК-ийн судалгаа хариуцсан дэд захирал болон холбогдох ажилтнуудтай уулзалт зохион байгуулж, судалгааны ажлыг зохион байгуулах хугацаа, хүний нөөц, зардал төсвийн тооцоог дахин хийж ажлын албанд ирүүлэхээр тохиров.

Үр дүн: Гишүүн байгууллагуудыг албан ёсны тоон мэдээллээр хангахад чухал ажил болсон.

СЭЗИС-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд Легал клиник ЮПЭ ХХК-тай хамтран ажиллаж, МБҮА ТББ-ын дүрмийн шинэчилсэн төслийг хянуулж, бэлтгэсэн дүрмийн төслийг ажлын


хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулж, УЗХ-д танилцуулан МБҮА ТББ-ын Бүх гишүүдийн чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Үр дүн: МБҮА ТББ-ын дүрэм шинэчлэгдсэнээр үйл ажиллагааны хүрээ болон хамтын ажиллагааг өргөжүүлэх, гишүүдийн эрх, үүргийг тодорхой болгох, санхүүгийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зэргээр байгууллагын ажиллагааг илүү үр дүнтэй, ил тод болгож, нийгэм болон гишүүдийнхээ эрх ашгийг илүү сайн хамгаалах, үйлчлэх боломжийг олгоно.

Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны цахим программын шилжилтийн асуудлаар ажлын хэсгийн 3 удаагийн хуралд оролцож, БҮАТЗ олгох төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх гэрээг 3 жилээр сунгах, цахим программын шилжилттэй холбоотой ХББОС-ын сайдын тушаалын төслүүд, гэрээний төслийг боловсруулан батлуулах ажилд оролцсон. МҮХАҮТ-ээс Төрийн чиг үүргийг мэргэжлийн төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхтэй холбоотой зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцож, төрийн чиг үүрэг гүйцэтгэх асуудлаар саналаа албан бичгээр хүргүүлсэн.

Үр дүн: Энэ нь барилгын чанар, хяналтыг улам сайжруулах, боловсронгуй болгоход МБҮА ТББ-аас хийж байгаа нэг чухал алхам болсон:

2025



БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MCIS.GOV.MN

"БАРИЛГЫН САЛБАРЫН ЗӨВЛӨГӨӨН 2025"-д МБҮА ТББ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ ШААРДЛАГЫН ТАЛААР ТАНИЛЦУУЛГА ХИЙЛЭЭ



Сүхбаатар, Хэнтий аймгийн "Барилгын салбарын зөвлөгөөн 2025" зохион байгуулагдаж байгаа бөгөөд зөвлөгөөнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Сүхбаатар, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар, ГХБХБГ, "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ, Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ зэрэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөлөл, холбогдох албаны хүмүүс оролцож байна.Уг зөвлөгөөнөөр барилгын салбарын өнөөгийн нөхцөл байдал, бодлого, хууль эрх зүйн асуудлуудыг хэлэлцэх, шинэчлэл, хөгжлийн төлөвлөгөөг танилцуулж салбарын мэргэжилтнүүд, орон нутгийн удирдлагууд болон төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор өргөн хүрээнд явагдаж байна. МБҮА ТББ-ын БҮАТЗХ-ийн дарга Э.Мөнгөнхундага нь тус аймгуудад Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн шинэ нөхцөл шаардлага хэрхэн өөрчлөгдсөн тухай болон тусгай зөвшөөрөл авахад шаардагдах баримтын бүрдэл, хэрхэн хандах тухай танилцуулга хийж, иргэд олон нийтэд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.

БАРИЛГЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ШИНЭ ЖУРАМ ИРЭХ САРААС ХЭРЭГЖИЖ ЭХЭЛНЭ

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Зөвшөөрлийн зөвлөлөөс улс даяар олгогдож буй тусгай зөвшөөрлүүдийг нэгдсэн нэг системээр олгож эхлэх шийдвэр гаргасан. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг ирэх 06-р сарын 10-аас эхлэн **license.mn** системээс авах боломжтой боллоо.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, Барилгын материалын хэлтсийн дарга Д.Батзориг, “Монголын Барилгын Үндэсний Ассоциаци” ТББ-ын ерөнхийлөгч Н.Баярсайхан, БҮАТЗХ-ийн дарга Э.Мөнгөнхундага нар системийн шинэчлэлтийн талаар танилцуулж, нэгдсэн мэдээлэл өглөө.


ХББОСЯ- аас олгодог Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, Барилга ажил гүйцэтгэх, Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг **license.mn** зөвшөөрлийн нэгдсэн системээр дамжуулан олгохоор боллоо.

Зөвшөөрлийн нэгдсэн систем **license.mn** нь Монгол Улсад тусгай зөвшөөрөл, эрх зүйн баримт бичиг, зөвшөөрөл шаардах үйл ажиллагааг нэг цонхоор цахимаар шийдвэрлэх зорилготойгоор хөгжүүлсэн бөгөөд барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг нэгдсэн системээр олгодог болсноор дараах давуу тал, шинэчлэлтийг бий болгоод байна.

📌Тус системд шилжсэнээр иргэн аж ахуйн нэгж байгууллагын хувьд дараах давуу талууд үүсэж байна Үүнд:

1.Хуучин системээр аж ахуй нэгж байгууллага нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээгээ авахдаа зөвшөөрөл олгогч байгууллагатай биечлэн очиж гэрээ байгуулдаг байсан бол тус системд

шилжсэнээр цахимаар гэрээ байгуулж цаг хугацаа хүний оролцоогүй болгож автоматжуулсан. Ингэснээр эрх бүхий байгууллагад биечлэн очих шаардлагагүй болж, цаг хугацаа, зардлыг хэмнэх нөхцөл бүрдсэн.



2. Хуучин системээр тусгай зөвшөөрлийн хүсэлт нь баталгаажиж сайдын тушаал гарсан тохиолдолд үнэт цаасан дээр бичилт хийж яамны сайдын гарын үсэг зурах, тамга тэмдэг дарах зэрэг хүний оролцоотой механик ажлуудад цаг хугацаа зарцуулдаг байсан бол одоо QR code бүхий нууцлалтай цахим гэрчилгээг тус системээр дамжуулан авах боломжтой болсон. Мөн хаяж гээж үрэгдүүлэх, алга болгох зэрэг асуудлыг хөнгөвчлөн шийдэж тусгай зөвшөөрлийн шийдвэрлэлт ил тод, нээлттэй боллоо.

3. Өмнө нь инженер техникийн ажилтан нь давхцалаа шалгуулах, аль байгууллагад бүртгэлтээ эсэхээ мэддэггүй байдал үүсдэг, бусад байгууллагаас хамааралтай байсныг болиулж Инженер техникийн ажилтан /ИТА/ зөвхөн өөрийн нэгдсэн нэвтрэлтээр орж бүртгэлээ хаана байгааг шууд шалгах боломжтой болсон.

4. Тухайн аж ахуйн нэгж байгууллага, ИТА хасалт хийлгэхийн тулд системээр дамжуулан хүсэлт гарах, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаар нэг байгууллагаас хамааралтай байсныг болиулж Инженер техникийн ажилтны шилжилт тухайн аж ахуйн нэгж байгууллага өөрөө хасдаг байдлыг бий болгосон нь тухайн компанийн хариуцлагыг нэмэгдүүлж байна.

5. Тухайн аж ахуйн нэгж бүртгүүлсэн и-мэйл хаягаа мартсан бол гуравдагч байгууллагад албан бичгээр хандан и-мэйл хаягаа авдаг, солиулдаг хүний оролцоотой цаг зав зарцуулдаг байсныг болиулж иргэн төрийн нэгдсэн мэдээллийн сандаа нэвтрээд имэйл хаяг бүртгэлтэй утсаараа дамжуулаад имэйл хаягаа авах боломжтой болсон.

6. Зөвшөөрөл олгох үйл явц ил тод нээлттэй болж, иргэд болон байгууллагууд хяналт тавих боломжтой болж байна.

7. Цаг хугацаа хэмнэж бүх материалыг онлайнаар бүрдүүлэх, илгээх боломжтой болсон тул оочер дараалал, цаас, бичиг баримт, хэвлэмэл материал, тээвэрлэлт, ажилчдын илүү цаг гэх мэт нэмэлт зардлууд буурна.

8. Шийдвэр гаргах хугацаа тодорхой, хурдан болно.

9. Иргэдийн хувьд ажил, амьдралын хуваарьт саад учруулахгүйгээр хүсэлтээ гаргах боломжтой.

10. Хүсэлт өгсөн, шийдвэрлэсэн төлөв, шат бүрийг иргэн өөрөө хянах боломжтой.

11. Цахим систем нь 24/7 ажиллах тул хүссэн цагтаа үйлчилгээ авах боломжтой.

📌 Тус системд шилжсэнээр төрийн байгууллагын хувьд дараах давуу талууд үүсэж байна Үүнд:

1. Тус систем нь төрийн мэдээллийн нэгдсэн сантай уялдаж байгаа тул зөвшөөрөлтэй бүх компаниудын мэдээлэл төвлөрч, хяналт, шинжилгээ хийхэд хялбар болно.

2. Тусгай зөвшөөрөл олгоход хүний оролцоог багасгаж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид үйлчилгээ үзүүлэх боломжтой болно.


3. Шийдвэр гаргалт, хяналтын процесс бүртгэгдэж үлддэг тул авлига, хүнд суртал буурна.

4. Төрийн үйлчилгээний тоо, чанар хүртээмж нэмэгдэж, ил тод, нээлттэй байдал сайжирна.
5. Төрийн бодлого, шийдвэр гаргах үйл явц болон үзүүлж байгаа үйл ажиллагаанд цахим хэлбэрээр оролцох боломж нэмэгдэнэ.
6. Хяналт, шалгалт үр дүнтэй болно.
7. Эрсдэлтэй байгууллагуудыг эрэмбэлэх, анхаарал хандуулах боломж бүрдэнэ.

Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг ирэх 06-р сарын 10-аас эхлэн license.mn системээс авах боломжтой.


АЖЛЫН АЛБАНЫ БҮАТЗХ-ИЙН “НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”-ИЙН 2025 ОНЫ 5 САРЫН ТОЙМ

БҮАТЗ-ийн хэлтэс нь “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан 1300 гаруй хуулийн этгээд, иргэдийг тухай бүр нь мэдээллээр ханган ажиллав.



БҮАТЗ-ийн хэлтэс нь “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан 1300 гаруй хуулийн этгээд, иргэдийг тухай бүр нь мэдээллээр ханган ажиллав.
БҮАТЗ-тэй холбоотой “Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудад тавих нөхцөл, шаардлагын дагуу барилгын тусгай зөвшөөрлийг хүссэн 517-н ААНБ-ын хүсэлт, материалыг баталгаажуулж, ХБӨОСЯ-нд 2025.05.01, 2025.05.08, 2025.05.15, 2025.05.22, 2025.05.26, 2025.05.29-ны өдрүүдэд тус тус цахимаар илгээв.





Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор **997** ААНБ-ын хүсэлт хянагдаж, **6** удаагийн БАТАЛГААЖУУЛАЛТ-аар **517** ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав.

Үүнээс: Сунгалтаар **37**, Нэмэлтээр **137**, Шинээр **336**, Дахин олгохоор **7** ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав. Сунгалтаар 37 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 33, Зураг төслөөр 4. Нэмэлтээр 137 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 92, Зураг төсөл боловсруулалтаар 42, Өргөх байгууламжаар 3, Шинээр 336

ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 282, Зураг төсөл боловсруулалтаар 48, Өргөх байгууламжаар 6, Дахин олгохоор 7 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 6, Зураг төслөөр 1 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав. Эдгээр 6 удаагийн баталгаажуулалтаар давхардсан тоогоор 480 ААНБ-ын материалыг шаардлага хангаагүйн улмаас буцааж, өнөөдрийн байдлаар 90 ААНБ-ын хүсэлтийг шалгахаар хүлээгдэж байна.

- Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад тавих нөхцөл, шаардлагын дагуу тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн 517 ААНБ-ын хүсэлтийн материалыг хянаж, 2237 инженер, техникийн ажилтнуудын баталгаажуулалтыг хийв.
- Хуульчдын холбооноос жил бүр зохион байгуулдаг “Хуульчийн про боно” өдөрлөг 2025 оны 05 дугаар сарын 1-ны өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан бөгөөд тус өдөрлөгт оролцож шинэчлэгдсэн “Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад тавих нөхцөл, шаардлага”-ыг олон нийтэд нээлттэй танилцуулж иргэн, хуулийн этгээдийн сонирхсон мэдээллийг хүргэж ажилласан.
- БҮАТЗ-ийг эзэмшигч хуулийн этгээдийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, 4 удаа ХББОСЯ-нд Улсын бүртгэлийн ерөнхий газрын *opendata.burtgel.gov.mn*-д БУ: 5173, ЗТ: 1012, ӨБ: 175 ААНБ-ын нийт 6360 ААНБ-ын мэдээллийг нээлттэй байршуулах хүсэлтийг хүргүүлэв.
- БҮАТЗ-тэй ААНБ-уудын мэдээллийн санг үүсгэн *www.mcis.gov.mn*-ын “Холбогдох бичиг баримт хэсэг”-т БУ: 5173, ЗТ: 1012, ӨБ: 175 ААНБ-ын нийт 6360н ААНБ-ын мэдээллийг нээлттэй байршуулав.
- Цахим Хөгжил, Харилцаа Холбооны Яам (ЦХХХЯ)-ны тусгай зөвшөөрлийн цахим системд БУ: 5173, ЗТ: 1012, ӨБ: 175 ААНБ-ын нийт 6360н ААНБ-ын мэдээллийг мэдээллийг хүргүүлсэн.
- ХББОСайдын тушаалыг үндэслэн 426 ААНБ-тай гэрээг байгуулж, Засгийн газрын “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох” тогтоолын дагуу 375,600,000 төгрөгийн Улсын тэмдэгтийн хураамжийг Худалдаа, хөгжлийн банкны дансанд төвлөрүүлэв.
- Үйлчилгээний хөлсний 571 ААНБ-ын 300,400,000 төгрөгийг Худалдаа, хөгжлийн банкны 240004000431006029 тоот дансаар төвлөрүүлэн ажиллав.

ХББОСайдын Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг шинээр болон нэмэлт ажлын төрлөөр олгох, сунгах тухай 2025.04.28-ний өдрийн №89 дүгээр тушаал, 2025.04.30-ны өдрийн №95 дугаар тушаал, 2025.05.02-ны өдрийн №96 дугаар тушаал, 2025.05.12-ны өдрийн №107 дугаар тушаал, 2025.05.16-ны өдрийн №115 дугаар тушаал, 2025.05.23-ны өдрийн №122 дугаар тушаал, 2025.05.27-ны өдрийн №128 дугаар тушаалыг үндэслэн 703 ширхэг үнэт цаасанд бичилтийг хийж, баталгаажуулав.

2025

ГИШҮҮНЧЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА



МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MNCA.MN

МБҮА ТББ-ын Гишүүнчлэлийнхээ тоог нэмж, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх зорилт, 2025 онд хэрэгжүүлэх Гишүүнчлэлийн мего төслийн хүрээнд гишүүнчлэлийн бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд таниулан хүргэхээр мэдээлэл постер бэлтгэн холбогдох мэдээ мэдээллийг өгч ажилласны үр дүнд 2025.05-р сард Гишүүнээр барилга угсралт, барилгын материал худалдаа, үйлдвэрлэлийн БОДЬ ПРОПЕРТИЙЗ ХХК, БЛЬЮ РАЙГЕЛЬ ХХК, ДЕЛЬТА ЛИФТ ХХК, АМААЦАЙ ХХК, НОБЭ ХХК болон ФЭЙРВИ ХХК, АРАВТ СЕКЬЮРИТИ СЕРВИС ХХК Дэмжигч гишүүнээр элслээ.

МБҮА ТББ НЬ ХОВД, БАЯН-ӨЛГИЙ, ДАРХАН-УУЛ АЙМГУУДАД САЛБАР ЗӨВЛӨЛТЭЙ БОЛЛОО

Монголын барилгын салбарын хөгжил, эрх зүйн орчныг сайжруулах, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилготой Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь үндэсний барилгын компаниудын нэгдэл болохын хувьд нийслэл төдийгүй орон нутагт үйл ажиллагаагаа өргөжүүлж салбар зөвлөл байгуулах ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд МБҮА ТББ-ын Салбарын бодлого, төлөвлөлт, судалгааны хэлтсийн дарга М.Энхбаатар, Ажлын албаны төлөөлөл орон нутгуудад ажиллалаа.

2025.05.02-ны өдөр Ховд аймагт 18 аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцож үүсгэн байгуулах хурлаа хийж үүсгэн байгуулагчаар 7 хүнийг сонгож Салбарын Тэргүүнээр Б. Туулайтулга сонгогдлоо.

2025.05.03-ны өдөр Баян-Өлгий аймагт 14 барилгын компаниудын төлөөлөлтэй хуралдаж тус аймаг дахь Салбар зөвлөлийн Тэргүүнээр Г. Жанисбекийг сонголоо.

2025.05.04-ны өдөр Дархан-Уул аймагт ажиллаж тус аймагт салбар зөвлөл байгуулах хуралд 13 аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцож тэргүүнээр С.Дэлгэрбаярыг 100 хувийн саналаар тус тус сонголоо. Өнгөрсөн хугацаанд МБҮА ТББ нь хөгжлийн стратеги төлөвлөгөөний дагуу өөрийн гишүүд,







салбарын ТББ-ууд болон Төрийн холбогдох байгууллагуудтай нягт хамтран ажилласны үр дүнд Монгол Улсын эдийн засагт тохиолдсон удаа дараагийн хямрал, хүндрэлүүдийг даван туулахад салбарын дуу хоолой болон манлайлан ажиллаж Төр засгаар тодорхой шийдвэрүүд гаргуулж, үр дүнд нь зөвхөн гишүүдэд төдийгүй энэ салбарт ажиллаж буй нийт бизнес эрхлэгчдэд эерэг нөлөөллүүд бий болгож ирсэн билээ. Мөн барилгын бизнесийн орчныг сайжруулах, зөвшөөрлийн тогтолцоог хялбаршуулах ажлыг манлайлан ажилласны үр дүнд энэ ажлыг өнөөдрийн байдлаар уг үйл ажиллагаа бүрэн цахимжиж, тусгай зөвшөөрлийн журмыг хялбаршуулан ажлын 5-7 хоногт зөвшөөрлөө авдаг болоод байна.

МОНГОЛЫН МЭРГЭЖЛИЙН ШАТ УГСРАГЧИД “MONGOLIAN SCAFFOLDERS CHAMPIONSHIP 2025” ТЭМЦЭЭНД УР ЧАДВАРАА СОРИЛОО









Өндрийн ажил мэргэжлийн холбоо ТББ-аас гурав дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж буй “MONGOLIAN SCAFFOLDERS CHAMPIONSHIP 2025” ур чадварын тэмцээн 2025.05.03,04-ны өдрүүдэд Оюу Толгой төслийн талбайд зохион байгуулагдлаа.

Монголын үндэсний баг тамирчдыг сонгон шалгаруулах зорилготой тус тэмцээн нь барилгын түр шат тавцангийн угсралтын чиглэлээр мэргэшсэн өндөр эрсдэлтэй мэргэжлийн ажилчдын дунд зохион байгуулагдаж буй улсын хэмжээний шалгаруулалт бөгөөд тэргүүлэгчид нь олон улсын тавцанд эх орноо төлөөлөн оролцох юм. Тус арга хэмжээ нь ур чадварыг сорихоос гадна барилгын гадна шат угсралтын салбарын мэргэжлийн төвшинг нэмэгдүүлэх, олон улсын жишигт нийцсэн стандарт, хариуцлага, аюулгүй ажиллагааг төлөвшүүлэх, цаашлаад уг чиглэлд тусгай зөвшөөрөл, норм стандарт бий болгох эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулах юм.

Шатны угсралтыг яагаад тусгай зөвшөөрөлтэй болгох шаардлагатай вэ? Өнөөдөр барилгын салбарт аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн хамгаалал маш өндөр шаардлагатай салбар болон хөгжиж байна. Ялангуяа барилгын түр шат, тавцангийн угсралт нь хүний амь нас, эрүүл мэндэд шууд хамааралтай, өндөр эрсдэлтэй мэргэжлийн ажил бөгөөд шат угсралтын ажлыг мэргэжлийн, тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар гүйцэтгүүлэх нь хүний амь нас, байгууллагын нэр хүнд, хариуцлагыг хамгаалах чухал алхам гэдгийг онцолж энэ талаар холбогдох төр болоод төрийн бус байгууллагуудад уламжилсан юм.

МБҮА ТББ-ын Дэд ерөнхийлөгч, НБИК ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Баяраагаар ахлуулсан баг 2023, 2024 оны дэлхийн шат угсралтын тэмцээнд амжилттай оролцож байсан туршлагатай бөгөөд МБҮА ТББ-ын зүгээс дэмжлэг үзүүлж оролцлоо.

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДЭД ФИДИК-ИЙН СУРГАЛТЫГ ХИЙЖ БАЙНА



МБҮА ТББ нь Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо (ФИДИК)-нд ТҮНШЛЭГЧ ГИШҮҮН-ий хувьд Монгол Улсын барилгын салбарт олон улсын гэрээ, эрх зүйн орчныг стандартын дагуу хэрэгжүүлэх, шинэ дэвшил, эргэлтийг авчрах таатай нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд ФИДИК-ИЙН ЖИШИГ ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ-үүд ээлжит сургалтаа 2025.05.14-ны өдөр “ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ийн мэргэжилтнүүдэд орлоо. Уг сургалтад ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ийн Ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны хэлтэс, Үйлдвэрлэл, технологийн парк төслийн нэгж, Баяжуулах үйлдвэр, Барилга байгууламжийн хяналт төлөвлөлтийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны бодлогын газар, Ногоон хөгжлийн төслийн нэгж, Санхүү нягтлан бодох бүртгэл, хуулийн хэлтэс, Дотоод хяналт мониторингийн хэлтэс, Хүний нөөц, захиргааны хэлтсийн 47 албан хаагч, мэргэжилтнүүд хамрагдаж байна.

Сургалтаар ФИДИК буюу Олон улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо, түүний үйл ажиллагааны тухай, ФИДИК-ийн жишиг гэрээнүүд, тэдгээрийн ялгаа, жишиг гэрээнээс хэрхэн сонгох тухай, өргөн хэрэглэгддэг Улаан, Шар болон Мөнгөлөг гэрээнүүдийн ялгаа, ФИДИК гэрээний бүтэц, Тусгай нөхцөл бэлтгэх зааварчилгаа, Алтан зарчим, Гэрээний талууд, тэдгээрийн эрх үүрэг, хариуцлагын зохицуулалт, Захиалагч, Инженер, Гүйцэтгэгчийн эрх, үүрэг, хариуцлага, Ажил эхлүүлэх, хойшлох, түр зогсоох, гэрээ цуцлах зохицуулалтууд, Ажил гүйцэтгэх явцын зохицуулалтууд, Гэрээний үнэ, төлбөр, баталгаа, даатгал, Зураг төсөл, дундын болон эцсийн туршилт, ажлыг хүлээж авах, Маргаан шийдвэрлэлтийн талаарх ойлголтыг авах бөгөөд сургалтад суусан инженерүүдэд мэргэжил дээшлүүлэх хоёр багц цаг олгож сертификат гардуулах юм.

ГИШҮҮДДЭЭ ЗОРИУЛАН БАРИЛГЫН ТӨСЛИЙГ ХЭРХЭН АМЖИЛТТАЙ УДИРДАХ ВЭ СУРГАЛТЫГ ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН ИНСТИТУТТЭЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛЛАА



МБҮА ТББ, PMI Mongolia Chapter буюу Төслийн Удирдлагын Институт хамтран гишүүн барилгын компаниудын захирал, удирдах ажилтнуудад зориулан төслийн менежментийн чиглэлээр онол, практикийг хослуулсан сургалтыг 2025.05.20-ны өдөр зохион байгууллаа. Энэхүү сургалт нь төслийн удирдлагын олон улсын стандартад суурилсан бөгөөд сургалтад оролцогчдыг мэргэжлийн түвшинд чадваржуулахад чиглэгдсэн ба нийт 30 гаруй гишүүн компаниудын захирал, менежер, ахлан инженерүүд идэвхтэй оролцсон юм. Сургалтыг 0PMI Mongolia Chapter буюу Төслийн Удирдлагын Институтын Сургалт хариуцсан захирал Г.Жавхлант заан, сургалтад оролцогчид дараах ур чадвар, мэдлэгээ өргөжүүлсэн юм. Үүнд:

- Олон улсын түвшний төслийн менежментийн мэдлэг эзэмших
- Төслийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх цогц ур чадвартай болох
- Agile болон уламжлалт аргачлалуудыг зөв хэрэглэж сурах



- Эрсдэлийг тооцоолж, шийдвэр гаргах чадвар нэмэгдүүлэх зэрэг болно.

МБҮА ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД БАТЛАН ХАМГААЛАХЫН ХӨГЖИЛ ДЭВШИЛТЭЙ ТАНИЛЦАЖ ӨНГӨРҮҮЛЛЭЭ



МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн БХЯ-ны Барилга Захиалагчийн алба ТӨААТҮГ-ийн захирал Э.Мөнхнарангийн урилгаар Удирдах зөвлөлийн гишүүд болоод бусад гишүүд нэг өдрийг Ардын армийн хөгжил дэвшил, Олон улсын энхийг сахиулах хүчний түүхэн замнал, үзэсгэлэн музейтэй танилцлаа.

Тус сургалтын төвд Олон улсын “Хааны эрэл”-д хээрийн сургуулилт болдог бөгөөд сүүлийн жилүүдэд дэлхийн томоохон орнуудын цэрэг армийнхан ирж Монгол Улсын зэвсэгт хүчнийхэнтэй хамтарсан бэлтгэлүүдийг хийдэг болоод байгаа юм байна.

Мөн Зэвсэгт хүчний жанжин штабаас нийгмийн сэдэвтэй контент бэлдэх гэж байгаагаа танилцуулсан бөгөөд МБҮА ТББ-ын гишүүдээ урьж хийх гэж байгаа болоод хийх ажлуудаа танилцуулсан Э.Мөнхнаран захиралдаа хамт олны нэрийн өмнөөс баярлаж талархсанаа илэрхийлье.

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР





CHINCA

CHINCA-тай хамтарч зохион байгуулах үзэсгэлэн яармагийн бэлтгэл ажлыг хангах, хэрхэн хамтран ажиллах чиглэлийг тодорхой болгох тал дээр ажиллав. 2025.06-р сард Макаод болох 16 дахь удаагийн Олон Улсын Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалт ба Барилгын Чуулга Уулзалт, Үзэсгэлэн Зохион байгуулахтай холбоотой ажлуудыг гүйцэтгэв. БНХАУ-ын ОЛОН УЛСЫН ГЭРЭЭЛЭГЧДИЙН ХОЛБОО (CHINCA)-тай хамтран зохион байгуулах ажилтай холбоотойгоор үзэсгэлэн зохион байгуулах талбай судлах ажил, үнийн судалгаа, хэдэн хүн хамрагдах, ямар хэлбэрээр зохион байгуулах, урьдчилсан төлөвлөгөө гаргахтай холбоотой ажлуудыг мэйл хаягаар болон wechat хэлбэрээр ярилцаж тохиролцов. Тус арга хэмжээг 2025.05.27 байдлаар THE CORPORATE CONVENTION CENTER-т нийт 150-200 хүний бүрэлдэхүүнтэйгээр, семинар зохион байгуулах, хурлын хажуугаар үзэсгэлэн зохион байгуулах хэлбэрээр ажиллах урьдчилсан төлөвлөгөөг ярилцаад байна. 16 дахь удаагийн Олон улсын дэд бүтцийн хөрөнгө оруулалт ба

Барилгын чуулга уулзалт, үзэсгэлэн зохион байгуулах хороо (IIICF) 2025.06.10-12-нд зохион байгуулагдахтай холбоотой бэлтгэл ажлыг хангах ажлуудыг мөн хийж гүйцэтгэж байна. Тус арга хэмжээнд оролцох МБҮА ТББ-ын төлөөлөгчийн холбогдох орчуулгын ажлууд, билет захиалга, урьдчилсан хөтөлбөр орчуулах ажил, буудал захилга, илтгэл орчуулах, намтар орчуулга тус арга хэмжээг зохион байгуулахтай холбоотой цаг үеийн мэдээ мэдээллийг цаг тухай бүрт хүргэх тал дээр зохион байгуулах холбоодтой хамтран ажиллалаа. Энэхүү арга хэмжээтэй холбоотойгоор мэдээ мэдээллийг хүргэх, цаашлаад МБҮА ТББ-ын гишүүн компанидад оролцуулах боломж бололцоог хангаж холбогдох зардал, гарах төсөв болон хөтөлбөр төлөвлөгөөтэй холбоотой ажлуудыг гарган гишүүдэд брошур хэлбэрээр хүргэж, бүртгэлийг баталгаажуулах зорилгоор бүртгэлийн форм үүсгэн ажиллалаа.

БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛС

БНТУ барилгын салбарын хамгийн том холбоо болох Барилгын Материал Үйлдвэрлэгчдийн Холбоотой хамтран ажиллах талаар мэйл илгээв. aerkal@imsad.org turkiyeimsad@hs02kep.tr iletisim@buildingsmartturkiye.org Турк улсын барилгын материалын холбоодтой холбогдон ажиллав. Үүний үр дүнд Турк талаас Dizayn Группээс өөрсдийн компани танилцуулга мэдээллийг илгээсэн холбогдох орчуулга хийв.

FIDIC

FIDIC-ын орчуулгын гэрээний ажлыг эрчимжүүлэх БАРИЛГЫН ТӨСЛИЙН FIDIC-Н ЖИШИГ ГЭРЭЭ болон Олон улсын ФИДИК-ийн Холбоотой холбогдох тал дээр мэйлээр харилцан ажиллаж байна. Мөн 2025.09.21-23 хооронд болох “CAPE TOWN 2025” форум зохион байгуулагдах ба үүнтэй холбоотойгоор холбогдох судалгаа, гарах үр дүн, ач холбогдол болон харгалзах төсөв зэрэг судалгааны ажлуудыг эхлүүлэн ажиллаж байна.

<u>Маркетинг, зар сурталчилгааны чиглэлээр:</u>

CRM, easy call, massmail, mass massage үйлчилгээнүүдийн ашиглалтыг хэвшүүлж, хэрэглээ болгох,

CRM, easy call, massmail, mass message ашиглах тал дээр идэвхтэй ажилсан. Масс мессеж илгээх тал дээр гишүүнчлэл хариуцсан менежерүүдэд систем дээр нэвтрэх эрх нээсэн. Холбогдох эрхээр нэвтэрч шаардлагатай масс мессеж илгээх бүрэн боломжтой болсон. Удирдах зөвлөлийн хурал болон PMI сургалтын зарыг масс мессеж хэлбэрээр гишүүн байгууллагын бүртгэлтэй утасруу хувьчлан илгээсэн.

- Хөрөнгө оруулалтын чуулгантай холбоотой төлөвлөгөө боловсруулж танилцуулсан. холбогдох мэдээллийг тогтмол өгч ажиллав.
- Нийт гишүүдийн уулзалт, чуулганы холбогдох маркетингийн төсвийн нэгтгэл боловсруулан ажиллав.
- Танилцуулга брошурыг англиар орчуулав.
- Удирдах зөвлөлийн хурал болон PMI сургалтуудын идэвхжүүлэлтийг масс мессеж ашиглан гишүүдэд түгээсэн.
- PMI сургалтын багшын гэрээ байгуулах ажлыг гүйцэтгэв.
- PortSIP UC app ашиглан өөрийн утаснаасаа гишүүн байгууллагууд руу ярих боломжтой үйлчилгээ идэвхжүүлэв.

2025

“ДУЛААН ШИЙДЭЛ2" ТӨСӨЛ



МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.DULAALGA.MN

БАЙДЛААР ДУЛААЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА









Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын санхүүжилтээр СХД-ийн 3-р хорооны иргэн, 7 ам бүлтэй н.Батболдынд хана, дээврийг жишиг байдлаар дулаалах ажлыг зохион байгууллаа. Уг ажлын хүрээнд 2025.04.22-нд тус газрын дарга Д.Мөнхбаатартай уулзаж, төслийн үйл ажиллагаа болон дулаалгын технологийн онцлог, давуу талын талаар санал солилцсоны үр дүнд "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хууль, журмын дагуу харьцуулсан тендерт оролцож шалгаран “Хамтран ажиллах гэрээ” байгуулан 2025.04.27-30-ны өдөр хийж гүйцэтгэсэн. Дулаалгын явцыг Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газраас дүрсжүүлж, түргэвчилсэн бичлэг болгосноо 4 дүгээр сарын 30-нд Засгийн газар, нийслэлийн удирдлагуудад үзүүлсэн. Энэ үеэр Монгол Улсын Засгийн газрын тэргүүн болон Эрчим хүчний сайд, хотын дарга, Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо гэх мэт албаны хүмүүст Төслийн ахлах инженер Ж.Ганхуяг нь төслийн үйл ажиллагаагаа товч танилцууллаа.

“CONSTRACTION MARKET-2025 FORUM” АРГА ХЭМЖЭЭНД “ДУЛААН ШИЙДЭЛ- II” ТӨСЛИЙН БАГ МЭДЭЭЛЭЛ ӨГЧ ОРОЛЦОВ







"Construction market 2025 forum" арга хэмжээг зорин ирсэн зочид төлөөлөгчдөд төслийн ажилтан төслийн үйл ажиллагаа болон дулаалга, эрчим хүч хэмнэлтийн талаар ач холбогдлыг тайлбарлан таниулсан. Энэ үеэр төслийн Fact sheet-14 ш, төслийн танилцуулга-36 ш, flyer-36 ширхэгийг тус тус тараасан байна.

"НОГООН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ НЬ" СЭДЭВТ БАНК БА БАРИЛГЫН БРИГАДУУДЫН ОНЛАЙН УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Огноо: 2025.05.02
Зохион байгуулагч: МБҮА ТББ
Хамтран зохион байгуулагч: МНСК
Хамрагдсан хүний тоо: 46
Эзэмшүүлсэн мэдлэг, мэдээлэл: Ногоон санхүүгийн танилцуулга, барилгын салбар дахь боломжууд, ногоон барилгын санхүүжилтийн шалгуур, шаардлагууд, эрчим хүчний



хэмнэлттэй орон сууцны зээлийн боломжууд, барилгын чанарын үнэлгээ ба баталгаажуулалт, банкны зүгээс барилгын бригадуудтай хамтран ажиллах боломж, нөхцөлүүдийн талаар нээлттэй мэдээл өгч хэлэлцүүлэг өрнүүллээ.

"ДУЛААН БАЙШИН"- АМИНЫ ОРОН СУУЦ НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГТ ТӨСЛӨӨ ТАНИЛЦУУЛАН ОРОЛЦОВ

ХББОСЯ-ны санаачилгаар Монгол Улсын барилга, бүтээн байгуулалт, барилгын салбарын мэргэжилтнүүд, ханган нийлүүлэгчдийг нэг дор цуглуулж, шинэ технологи, тогтвортой хөгжил, олон улсын шилдэг практик туршлага, чанар стандартыг хэрхэн нэвтрүүлэх, барилга, орон сууцжуулалтын салбарт авч хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийг иргэд, олон нийтэд танилцуулах зорилго бүхий “Дулаан байшин” амины орон сууцны нээлттэй өдөрлөг Сүхбаатарын талбайд зохион байгуулагдаж **"**Дулаан шийдэл II"- төслийн зүгээс нээлттэй мэдээлэл өгч оролцлоо. Арга хэмжээний хөтөлбөрийн дагуу, манай баг “Барилгын эрчим хүч хэмнэлтийн шийдлүүд” сэдвээр илтгэл тавьсан.

Огноо: 2025.05.04-05.07-ны өдрүүдэд

Зохион байгуулагч: Хот байгуулалт, барига орон сууцжуулалтын яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Эрчим хүчний яам, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний







хороо, Нийслэлийн засаг даргын тамгын газар хамтран зохион байгуулав.

"ДУЛААН ШИЙДЭЛ II"-ТӨСЛИЙН ХӨНДЛӨНГИЙН ЗӨВЛӨХ ХОРООНЫ ХУРАЛ БОЛЛОО

“Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны төсөл, хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх боломж” сэдвээр болсон тус хуралд МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх: "Манай байгууллага нь Дулаан шийдэл төслийг 2018 оноос хойш хамтран хэрэгжүүлж байна. Энэ хугацаанд 200 гаруй барилгын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчийг дулаалгын технологи, барилгын дулаан хамгаалалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, хог хаягдлын менежмент, бизнесийн ёс зүй зэрэг чиглэлээр чадавхжуулж, дулаалгын зах зээлд холбон зуучилж, нэмэлт орлого олох боломжоор хангалаа.







Цаашид барилгын дулаалгын чиглэлээр мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх тал дээр анхаарч ажиллах болно. Мөн амины орон сууцыг анхнаас нь зураг төсөлтэй барьдаг байх талаар холбогдох хууль, дүрэм журамд өөрчлөлт оруулахад анхаарч ажиллая гэж төлөвлөж байна. Цаашид бид илүү олон дулаалгын зөвлөхийг бэлтгэх, олон айл өрхийг дулаан, тав тухтай байх нөхцөлийг хангахын төлөө дотоод нөөц бололцоогоо ашиглахын зэрэгцээ гадаадын хөрөнгө оруулалт татах, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахыг зорьж байна" гэдгээ илэрхийлсэн юм.

Зохион байгуулагч: “Жэрэс” ОУТББ

Оролцогч: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, Амины орон сууцны инновац хөгжлийн төв, Хас банк, Росторг ХХК мөн төслийг хамтран хэрэгжүүлэгчид зэрэг төрийн болон төрийн бус байгууллага, банк санхүү, хувийн хэвшлийн төлөөллүүд оролцов.

УИХ-ЫН ГИШҮҮН Г.ЛУВСАНЖАМЦЫН АЖЛЫН АЛБАНААС ДУЛААН ШИЙДЭЛ- II ТӨСЛИЙН ДУЛААЛСАН БАЙШИНТАЙ ТАНИЛЦЛАА











Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй Дулаан шийдэл төсөл нь 2018 оноос хойш 4854 байшин дулаалж, 274 барилгын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг барилгын дулаалгын технологид суралцуулан, чадавхжуулаад байна. Тус төсөл нь хувийн сууцны салбар дахь тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэл рүү чиглэсэн бодлогыг дэмжин, Монголын нөхцөлд нийцсэн, үр ашигтай эрчим хүчний шийдлүүдийг боловсруулан нэвтрүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмрээ оруулан, эрүүл мэнд, эдийн засаг, нийгмийн хувьд үр ашигтай байх зах зээлийг бий болгох зорилгоор хэрэгжүүлж байна.

Зорилго:

- “Дулаан шийдэл II” төслийн хүрээнд бүтэн дулаалга хийсэн СХД-ийн 22-р хорооны иргэн Г.Хүрэлбаатарын

байшинг танилцуулах замаар дулаалга, эрчим хүч хэмнэлтийн талаар төр, хувийн хэвшил, иргэдэд тайлбарлан таниулах

- Дулаалга хийлгэснээр гарсан үр дүнгийн талаар айл өрхийн байр суурь, сэтгэгдлийг сонсох, дулаалгын технологийн талаар Төслийн инженер, гүйцэтгэгчидтэй ярилцлаа.











“ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСӨЛТЭЙ ШИНЭЭР ХАМТАРЧ АЖИЛЛАХ 16 БАРИЛГЫН САЛБАРЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧИДТЭЙ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА


Зорилго: "Дулаан шийдэл II" төслийн хүрээнд МБҮА ТББ-тай Хамтран ажиллах Санамж бичиг байгуулах, төслийн дулаалгын зөвлөхөөр ажиллах талаар зөвлөмж өгөх, айл өрхийн байшингийн дулаан алдагдлыг илрүүлэх, дулаалгын үнэлгээ гаргахад шаардлагатай багц гардуулах, төслийн ажилд зуучлах, нэмэлт орлого олох нөхцөлийг бүрдүүлэх гэх мэт зорилгын хүрээнд хийгдлээ.

“ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙН 2022-2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ НЭГТГЭН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭЛЭЭ



ДУЛААЛГЫН ЦАХИМ СИСТЕМИЙГ БҮРЭН, ХЭВИЙН АЖИЛЛАГААНД ОРУУЛАХ АЖИЛ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА


Зураг 1



3. Дулаалгын үндсэн ажлын гүйцэтгэл

Ажилбарын үе шат: Тус цэсэд зөвхөн "Ханын холболттой дулаалгын үе шат" -аас сонгох сонголттой бөгөөд цэсээс заавал сонголт хийснээр дараагийн алхамд орж хадгалагдах төлөвтэй тул Дулаалгын зөвлөх мөн нэг бүрчлэн "Нэмэлт мэдээлэл" цэсэд доорх мэдээллийг бичиж зөрүүтэй акт үйлдэгдэх болж байна. /Зураг 2/

Зураг 2



Dulaalga.mn системд дулаалгын ажлын акт үйлдэхэд гарсан хүндрэл

"Агаар салгалттай ханын дулаалгын ажлын гүйцэтгэлийн акт", "Дээвэр, адрын хөндийн дулаалгын ажлын гүйцэтгэлийн акт", "Суурийн холболттой дулаалгын ажлын акт" -ыг бөглөх явцад:

1. **Дулаан түгээлтэд, холбох материалын үзүүлэлт (гүйцэтгэлээр)**

"Марк" Мастер дата цэсэд холбогдох маркийг шинэ оруулан хадгалсан боловч, актыг бөглөх явцад сонгогдохгүй байна. Гэхдээ үүний "Нэмэлт мэдээлэл" хэсэгт оруулаад явахад асуудалгүй л юм байна.

2. **Дулаалгын бэлтгэл ажлын гүйцэтгэл**

Бэлтгэл ажлын үе шат: Системд зөвхөн "Шалны дулаалга, ханын дулаалга"-ын ажлын үе шатаас сонголт хийх боломжтой бөгөөд бусад дулаалгын ажлын үе шат болох дор дурдсан мэдээллүүдийг сонгох боломжгүй байгаа тул "Нэмэлт мэдээлэл" хэсэгт нийтээр нь тэмдэглэж оруулахаас өөр арга гүй байна. Энэ оруулснаар үе шат нь бүрд оруулсан зүйлүүдыг шалгах явцад ялгах болон доорх бичээрүүдийг дулаалгын зөвлөхөөс нэг бүрчлэн бичиж хүндрэлтэй байна. /Зураг 1/

Агаар салгалттай ханын дулаалгын ажлын гүйцэтгэлийн акт

- Дулаалгын материалыг бахлахийг хориглосон дранкт шаварлага, 12см-н тоостон хана, фасадын элементүүдийг бүртгасан.
- Гадаргуут тэгшилгэ, тоос, шороонооос цэвэрлэсэн.

Дээвэр, адрын хөндийн дулаалгын ажлын гүйцэтгэлийн акт

- Адрын хөндийд байрлах үнс, шар шаварт, үртэс, картон цаас, керамзит зэргийг бууллаж цэвэрлэсэн.
- Үжилд орсон элементийг солих хүчитгэсэн;
- Дээвэр ус нэвтрэхээргүй байгаа эсэх, яндан ормын хоолойн битүүмжийг нягталсан.

Суурийн холболттой дулаалгын ажлын гүйцэтгэлийн акт

- Суурийн усны хаваарийг бууллаж зайлуулсан
- Суурийн нягтаршуулсан хөрсийг хамгийн багадаа 30см гүнтэй ухсан.
- Суурийн бетоныг цэвэрлэж бэлтгэсан
- Хаалга, цонх, барилгын гадна хананы дотор ба гадна бүлангуудад намалт бахэлгээний тор наасан.
- Хаалга цонхны дотор болон гадна бүлангуудад цууралтаас хамгаалах нэмэлт тор наасан.
- Хүчитгэх торыг гадна цавуут зуурмагт живүүлж байдлаар жигд хийсэн.
- Хөрсжүүлэгчийг бүх гадаргууд жигд түрхсэн.
- Гадна өнгөлгөө хийсэн.

4. Акт нэмэх: Дулаалгын зөвлөх ажил дууссаны дараа "Акт" сонгох цэсэс үйлдэх актаа сонгоҗроо санамсаргүй дутуу сонгосон тохиолдолд дахин зөвшөөрөл хийж акт нэмж болдогүй юм байна.

Жич: Дээрх асуудлыг бодит харагдацийн өөрчлөлтөөр шалгасан болно.

"МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ" ТББ

2025.05.22

"ДУЛААН ШИЙДЭЛ-2 ТӨСӨЛ"-ИЙН БАГИЙН 5-Р САРД

ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОЙМ

Д/Д	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ТООН ҮЗҮҮЛЭЛТ
1.	ББЖБЭ-дэд зуучилсан техникийн үнэлгээний захиалга	69
2.	Техникийн үнэлгээний захиалгыг хуваарилсан ББЖБЭ-ийн тоо	20
3.	ББЖБЭ-ийн хийж гүйцэтгэсэн техникийн үнэлгээний тоо	28
4.	ББЖБЭ-дэд зуучилсан дулаалгын ажлын тоо	4
5.	ББЖБЭ-дэд зориулан зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	1
6.	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээнд оролцсон ББЖБЭ-ийн тоо	55
7.	Арга зүйн зөвлөмжийг өгсөн ББЖБЭ-ийн тоо	42
8.	Техникийн үнэлгээ, дулаалга болон барилгын ажлын талаар гарсан санал, хүсэлт, гомдлыг нь шийдвэрлэсэн харилцагчдын тоо	12
9	Техникийн үнэлгээний дадлага хариуцсан Бригадын ахлагчийн тоо	4
10	Техникийн үнэлгээний дадлагад гарсан ББЖБЭ-ийн тоо	18

МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

БАЙГУУЛЛАГЫГ СУРТАЛЧЛАХ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХҮРЭЭНД:







www.mnca.mn

Тухайн сард сарын байгууллагын мэдээ мэдээлэл буюу нийт 32 мэдээ, 16 рийл, 3 видео ярилцлага авч 1,700,000 гаруй хүнд хүргэж ажилласан ба









🚕🚗🚚ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГААС ОДОО ШУУД НЭВТРҮҮЛЭХ ЦАГ НЬ БОЛСОН БАЙНА



📌✍️МБҮА ТББ-ЫН ГИШҮҮДДЭЭ ЗОРИУЛАН БАРИЛГЫН ТӨСЛИЙГ ХЭРХЭН АМЖИЛТТАЙ УДИРДАХ ВЭ СУРГАЛТЫГ ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН ИНСТИТУТТЭЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛЛАА



🏗️👷‍♂️👩‍💼🌍⚖️БАРИЛГА, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТӨСӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭХЭЛСЭНТЭЙ ХОЛБОГДУУЛАН БАРИЛГЫН ТАЛБАЙ ДАХЬ ОСОЛ, ЭНДЭГДЛИЙН МЭДЭЭЛЭЛ ӨДӨР БҮР ГАРЧ БАЙНА. ИЙМД МБҮА ТББ НЬ... See more



МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан: 🏗️🏠ХБББОСЯ-ТАЙ БАЙГУУЛСАН 4 УДААГИЙН ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ДЭЭР САЛБАРЫН МЭРГЭЖЛИЙН ТББ-УУДЫН ТҮНШЛЭЛИЙН ХАМТААР БҮАТЭ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГА... See more





МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Монгол Улс, Улаанбаатар 15141,
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот

7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn